



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/02-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Баруунбүрэн сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	11
3.4.2 Авлага	11
3.4.3 Бараа материал.....	12
3.4.4 Үндсэн хөрөнгө	13
3.4.5 Өр төлбөр	14
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо	14
3.4.6 Зардлын данс	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	19
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.7.1 Завсрын аудитын талаар	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	22
5.1 Төлбөрийн акт	22
5.1 Албан шаардлага	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХАА	Хөдөө аж ахуй
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



Б А Р У У Н БҮ Р Э Н С У М Ы Н З А С А Г
Д А Р Г А Ц. С Э Л Э Н Г Э Т А Н А А

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.25 № СБА-2023/02-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баруунбүрэн сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтээс татварын ба татварын бус орлогын бүрдүүлэлт 2.5 дахин давж биелсэн боловч төсвийн гүйцэтгэл 75.4 хувьтай тайлагнагдсан нь ОНХС-ийн эх үүсвэрээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 19.5 хувь нь хэрэгжээгүй, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 99.9 хувийг олгоогүй зэргээс голлон шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Баруунбүрэн сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 30.9 хувь буюу 426,526.0 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 284,685.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 45,910.8 мянган төгрөг, нормативт

018020371

зардалд 784.5 мянган төгрөг, тавилга эд хогшил, урсгал засварын зардалд 33,236.7 мянган төгрөг бараа үйлчилгээний бусад зардалд 42,263.1 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгд 51,297.3 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 616,972.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	991,220.6	1,237,858.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	497,660.6	991,069.5
33	АВЛАГА	123,180.6	83,458.2
35	БАРАА МАТЕРИАЛ	370,379.4	163,330.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,936,342.4	2,218,011.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,936,342.4	2,218,011.6
39200	Биет хөрөнгө	3,867,114.4	2,193,664.4
39300	Биет бус хөрөнгө	69,228.0	24,347.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,927,563.0	3,455,869.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,880.8	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,880.8	0.0
41300	Өглөг	1,880.8	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,925,682.2	3,455,869.7
51	Засгийн газрын хувь оролцоо	4,925,682.2	3,455,869.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,245,916.6	278,919.3
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,245,916.6	278,919.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,542,215.9	2,966,226.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,137,549.7	210,724.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,927,563.0	3,455,869.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,129,319.1	2,675,968.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	329,055.1	835,416.10
110	Орлогын албан татвар	77,721.4	184,376.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	77,721.4	184,376.10
113	Хөрөнгийн албан татвар	169,029.9	107,672.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	82,303.7	543,367.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	358,426.9	609,359.30
120	Нийтлэг татварын бус орлого	358,426.9	609,359.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,441,837.1	1,231,193.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,813,291.5	1,088,691.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,813,291.5	1,088,691.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,817,943.8	1,060,858.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,575,827.2	383,363.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	208,509.8	48,204.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,346.3	285,603.50
2104	Хангамж, бараа материалын зардал	104,859.0	61,163.40
2105	Нормативт зардал	237,050.9	826.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,075.9	19,835.10
2107	Томилолт, зочны зардал	2,137.4	9,074.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,123.6	21,164.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	429,013.8	231,623.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	995,347.7	27,833.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	316,027.6	1,587,277.10
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	9,500.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	193,327.7	3,062,279.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	122,699.9	-1,465,502.30

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,824,322.3	0.0	4,824,322.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-21,340.0	0.0	-21,340.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,802,982.3	0.0	4,802,982.3
9	Тайлант үеийн үр дүн	122,699.9	0.0	122,699.9
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,925,682.2	0.0	4,925,682.2
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,925,682.2	0.0	4,925,682.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-383,087.6	0.0	-383,087.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,542,594.6	0.0	4,542,594.6
19	Тайлант үеийн үр дүн	-1,465,502.3	0.0	-1,465,502.3
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,455,869.7	0.0	3,455,869.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,936,474.9	2,240,612.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	329,055.1	835,416.1
110	Орлогын албан татвар	77,721.4	184,376.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	77,721.4	184,376.1
113	Хөрөнгийн албан татвар	169,029.9	107,672.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	82,303.7	543,367.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,522.7	23,827.5
1181	Газрын төлбөр	0.0	48,926.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	68,781.1	470,614.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	170,384.8	174,002.4
120	Нийтлэг татварын бус орлого	170,384.8	174,002.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,437,035.0	1,231,193.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,481,880.3	911,513.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,481,880.3	911,513.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,484,651.8	883,680.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,574,837.2	385,028.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	208,309.0	48,405.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,250.7	285,603.5
2104	Хангамж, бараа материалын зардал	94,669.3	53,339.1
2105	Нормативт зардал	227,124.1	1,724.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,982.5	20,810.1
2107	Томиллолт, зочны зардал	2,137.4	9,074.6

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,124.2	38,472.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,217.4	41,222.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	997,228.5	27,833.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	454,594.6	1,329,098.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	239,991.6	835,689.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	239,991.6	835,689.8
2200	Дотоод эх үүсвэрээр	239,991.6	835,689.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-239,991.6	-835,689.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-67,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	67,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	147,603.0	493,409.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	350,057.5	497,660.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	497,660.6	991,069.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,832,950.1	1,382,416.3	-450,533.8	75.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,033,577.7	885,359.0	-148,218.7	85.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	982,280.4	859,205.6	-123,074.8	87.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,430.7	378,873.3	-58,557.4	86.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,784.3	47,652.7	-7,131.6	87.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	334,977.0	284,685.7	-50,291.3	85.0
2104	Хангамж, бараа материалын зардал	46,567.2	45,910.8	-656.4	98.6
2105	Нормативт зардал	784.5	784.5	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,236.7	29,730.6	-3,506.1	89.5
2107	Томилолт, зочны зардал	10,725.1	9,074.6	-1,650.5	84.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,511.8	20,871.4	-640.4	97.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,263.1	41,622.0	-641.1	98.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,297.3	26,153.4	-25,143.9	51.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,297.3	26,153.4	-25,143.9	51.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	616,972.4	497,057.3	-119,915.1	80.6

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	182,400.0	0.0	-182,400.0	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,832,950.1	1,375,079.8	-457,870.3	75.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,492,298.2	1,289,825.0	-202,473.2	86.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	340,651.9	85,254.8	-255,397.1	25.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	207,963.8	207,963.8	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	200,627.3	200,627.3	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	102	96	-6	94
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	50	47	-3	94
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	50	47	-3	94

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	364,882.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,450.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,674.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,155.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	752.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	917.8
2104	Хангамж, бараа материалын зардал	7,428.3
2105	Нормативт зардал	940.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,079.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,601.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,775.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,680.0
3133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	95.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	326,432.5
2200	Дотоод эх үүсвэрээс	326,432.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	364,882.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	364,882.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “*Эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлалд түшиглэсэн бизнес нь тогтвортой хөгжсөн, иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин бүрдсэн хөгжлийн түвшингээрээ аймагтаа тэргүүлэх сумдын нэг болох*” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*

- *Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,*
- *Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ. Тайлант онд санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баруунбүрэн сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,760,088.8 мянган төгрөгөөр буюу 35.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	497,660.6	991,069.5	493,408.9
Авлага	123,180.6	83,458.3	(39,722.3)
Бараа материал	370,379.4	163,330.3	(207,049.1)
Үндсэн хөрөнгө	3,936,342.4	2,218,011.6	(1,718,330.8)
Нийт хөрөнгө	4,927,563.0	3,455,869.7	(1,471,693.3)
Өр төлбөр	1,880.8	0.0	(1,880.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,925,682.2	3,455,869.7	(1,469,812.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,927,563.0	3,455,869.7	(1,471,693.3)

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсныг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 991,069.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 493,408.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	497,660.6	991,069.5	493,408.9
Төгрөг	497,660.6	991,069.5	493,408.9
Төрийн сангийн харилцах	497,660.6	991,069.5	493,408.9
Дүн	497,660.6	991,069.5	493,408.9

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 790,488.9 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 89,287.9 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 111,292.7 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 83,458.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 39,722.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	200.0	0.0	(200.0)
Зээлийн хүүгийн авлага	3,242.1	3,242.1	0.0
Байгууллагаас авах авлага	5,632.8	1,522.7	(4,110.1)
Хувь хүмүүсээс авах авлага	4,066.7	4,066.7	0.0

Хувь хүмүүст олгосон зээл	110,039.0	74,626.8	(35,412.2)
Дүн	123,180.6	83,458.3	(39,722.3)

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 4,066.7 мянган төгрөгийн итгэлийн зээлийн авлага байна.

Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 93.3 хувь буюу 77,868.9 мянган төгрөгийг хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл эзэлж байна.

Насжилт өндөртэй буюу 2011-2018 оны хооронд олгосон хугацаа хэтэрсэн зээлийн 20,900.1 мянган төгрөгийн авлагыг холбогдох шатны шүүхэд хандаж барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын Ойн анги нь төлбөр тооцоог хянаагүйгээс ажилчидтай холбоотой 143.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 147,639.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 222,739.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	47,830.7	0.0	(47,830.7)
Тусгай зориулалттай материал	23,972.5	0.0	(23,972.5)
Эм боох материал	23,858.2	0.0	(23,858.2)
Хангамжийн материал	322,548.7	147,639.8	(174,908.9)
Бичиг хэргийн материал	20,406.1	4,959.8	(15,496.3)
Аж ахуйн материал	231,434.3	82,316.9	(149,117.4)
Сэлбэг хэрэгсэл	0.0	0.0	0.0
Түлш, шатах тослох материал	0.0	0.0	0.0
Хүнсний материал	1,277.0	0.0	(1,277.0)
Бусад хангамжийн материал	69,431.3	76,053.6	6,622.3
Мал амьтад	0.0	0.0	0.0
Дүн	370,379.4	163,330.3	(207,049.1)

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 207,049.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 613,293.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 66,008.4 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан болон 661,714.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан, бүтцийн өөрчлөлтөөр сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд нь улсын төсөвт байгууллага болсноор хаалтын тайлан гаргаж, тухайн байгууллагуудын 224,240.9 мянган төгрөгийн бараа материал шилжүүлсэн, 395.9 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

- Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгдээгүй нийт

6,296.8 мянган төгрөгийн /ЗДТГ нь 5,296.8 мянган төгрөг, Ойн анги 1,000.0 мянган төгрөг/ бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй болон бөөн дүнгээр баталгаажуулсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,283,856.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,065,818.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,275,091.3	3,257,013.3	(2,018,078.0)
Барилга, байгууламж, орон сууц	2,899,236.0	1,289,068.3	(1,610,167.7)
Авто-тээврийн хэрэгсэл	297,673.9	299,411.4	1,737.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	552,994.3	221,460.1	(331,534.2)
Тавилга, аж ахуйн эд хогшил	403,951.4	145,560.9	(258,390.5)
Номын фонд	91,523.2	55,347.2	(36,176.0)
Бусад үндсэн хөрөнгө	1,029,712.5	1,246,165.4	216,452.9
Биет бус хөрөнгө	74,583.8	26,843.0	(47,740.8)
Программ хангамж	10,620.0	3,950.0	(6,670.0)
Бусад биет бус хөрөнгө	63,963.8	22,893.0	(41,070.8)
Дүн	5,349,675.1	3,283,856.3	(2,065,818.8)

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос /анхны өртгөөр/ 2,065,818.8 мянган төгрөгөөр буурсан нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 193,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж /Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн албан хаагчдын 4-н айлын орон сууцын барилгыг 180,000.0 мянган төгрөгийн өртөгтэй барьж ашиглалтад оруулсан, ОНХО-аар үйлчилгээний ногоон барилгыг 13,000.0 мянган төгрөгөөр засварлаж капиталжуулалт хийсэн/,
- Үнэ төлбөргүйгээр 59,686.7 мянган төгрөгийн бусад хөрөнгө хүлээн авсан,
- ОНХС, ОНХО-аар хийгдсэн 404,760.6 мянган төгрөгийн хөрөнгө /ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 122,545.5 мянган төгрөгийн халуун усны барилга, 38,277.2 мянган төгрөгийн 3 ширхэг худаг, 20,635.0 мянган төгрөгийн малын халдварт өвчнөөс хамгаалах ариутгагч төхөөрөмж, 66,194.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай, 88,919.4 мянган төгрөгийн доод өлийн давааны засвар, 32,016.9 мянган төгрөгийн Зүүвчийн гармын засвар, 5,911.4 мянган төгрөгийн сумын төсвийн сайжруулсан замын засвар, 20,442.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, БОАЖГ-аас 4,818.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,000.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө/ орлогод авсан,
- 57,000.0 мянган төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгсэл /Аймгийн БОАЖГ-аас Ланд Крузэр Тоёота 150 маркийн/ шилжүүлж авсан зэрэг нийт 714,447.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол,

- Сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд нь улсын төсөвт байгууллага болсноор хаалтын тайлан гаргаж, тухайн байгууллагуудын 2,780,266.1 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж хасагдсанаас шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Өр төлбөрийн данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1,880.8	0.0	(1,880.8)
Дүн	1,880.8	0.0	(1,880.8)

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст өр төлбөр данс үлдэгдэлгүй тайлагнагдсан нь 1,880.8 ЗДТГ-ын гэрээт ажилтнуудын /усан сангийн ажилтнууд/ цалингийн өглөгийг барагдуулснаас шалтгаалсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,455,869.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,471,693.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,245,916.6	278,919.3	(966,997.3)
Хуримтлагдсан үр дүн	2,542,215.9	2,966,226.3	424,010.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,137,549.7	210,724.1	(926,825.6)
Дүн	4,925,682.2	3,455,869.7	(1,469,812.5)

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл урьд оноос 29.8 хувиар буурсан нь тайлант үеийн үр дүн 1,465,502.3 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

3.4.6 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **10,395.2** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Орхон бүсийн ойн ангийн техникч Д.Дарханцэцэгт олгосон **450.0** мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй.
- Сумын ЗДТГ нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас хоол, хүнсний материалын зардалд 8,050.2 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 1,895.0 мянган төгрөг зэрэг нийт **9,945.2** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Баруунбүрэн сумын ИТХ-ын 2021 оны “2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 43 дугаар тогтоолоор 349,614.7 мянган төгрөгийн татварын орлого, 20,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 925,623.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2.5 дахин давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	349,614.7	835,416.1	485,801.4	239.0
Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	135,000.0	133,692.0	(1,308.0)	99.0
Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	33,000.0	23,788.9	(9,211.1)	72.1
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	10,000.0	7,162.2	(2,837.8)	71.6
Хөрөнгийн орлого	20,500.0	21,335.1	835.1	104.1
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	5,500.0	5,560.0	60.0	101.1
Бууны албан татвар	540.0	450.0	(90.0)	83.3
Малд ногдуулах албан татвар	-	100,060.1	100,060.1	
Улсын тэмдэгтийн хураамж	7,000.0	20,500.5	13,500.5	292.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,100.0	1,663.3	563.3	151.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,000.0	1,663.7	(336.3)	83.2
Газрын төлбөр	29,546.6	48,926.1	19,379.5	165.6
Газрын дуудлага худалдаа	21,439.0	-	(21,439.0)	-
Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр	79,337.1	104,558.0	25,220.9	131.8
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	2,262.0	1,542.0	(720.0)	68.2
Байгалийн ургамал ашигласны төлбөр	2,390.0	364,514.1	362,124.1	15,251.6
Татварын бус орлого	20,000.0	90,207.7	70,207.7	451.0
Хүү, торгуулийн орлого	15,000.0	41,847.0	26,847.0	279.0
Бусад орлого	5,000.0	48,360.7	43,360.7	967.2
Нийт дүн	369,614.7	925,623.8	556,009.1	250.4

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд хөрөнгийн орлого 835.1 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 60.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 13,500.5 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 563.3 мянган

төгрөгөөр, газрын төлбөр 19,379.5 мянган төгрөгөөр, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр 25,220.9 мянган төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 362,124.1 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 1,308.0 мянган төгрөгөөр, ХХОАТ-ын орлого 9,211.1 мянган төгрөгөөр, бууны албан татвар 90.0 мянган төгрөгөөр хог хаягдлын үйлчилгээний хураамж 336.3 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 21,439.0 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр 720.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Малд ногдуулах албан татвар 100,060.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь ИТХ-ын батлагдсан төсвийн төлөвлөгөөнд орлогоор тусгаагүйгээс шалтгаалсан байна,
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 13,500.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь төрөөс иргэдэд үйлчилдэг бүх төрлийн үйл ажиллагаа нэмэгдсэнээс шалтгаалсан,
- Газрын төлбөр 19,379.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь урьд онд газрын төлбөр тушаагаагүй иргэд төлбөрөө нөхөж тушааснаас шалтгаалсан,
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр 25,220.9 мянган төгрөгөөр давсан нь сумын бүс нутагт мод бэлтгэл өссөнтэй холбоотой,
- Байгалийн ургамал ашигласны төлбөр 362,124.1 мянган төгрөгөөр давсан нь тайлант жилд сумын бүс нутагт самар их хэмжээгээр ургаснаас шалтгаалсан,
- Хүү, торгуулийн орлого 26,847.0 мянган төгрөгөөр давсан нь замын хөдөлгөөний зөрчил их гарсантай холбоотой,
- Бусад орлого 43,360.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь иргэдийн бэлтгэсэн хадлангийн төлбөрийн хураамжийн орлого орсноос шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- ХХОАТ-ын орлого 9,211.1 мянган төгрөгөөр тасарсан нь ноосны урамшууллаас суутган тооцсон ХХОАТ орж ирээгүй,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 2,837.8 мянган төгрөгөөр тасарсан нь сумын нутаг дэвсгэрт бүртгэлтэй иргэн, ААН байгууллагын үл хөдлөх хөрөнгө борлуулалт бага байснаас шалтгаалсан,
- Газрын дуудлага худалдааны орлого 21,439.0 мянган төгрөгөөр тасарсан нь тайлант онд газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 950,966.7 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 209,340.0 мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос 7,500.0 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого,

зарлагыг 1,167,806.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 31 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 369,614.7 мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 619,907.2 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлогыг 34,125.0 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 316,938.1 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 419,170.3 мянган төгрөг, ХХС-ийн орлогоос 110,000.0 мянган төгрөг зэрэг нийт **1,889,755.3** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 43 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг бууруулж 1,832,950.1 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 68,653.5 мянган төгрөгөөр, цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 20,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан,
- ИТХ-ын урсгал зардлыг 27,997.8 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын урсгал зардлыг 47,087.5 мянган төгрөгөөр, соёлын төвийн тогтмол зардлыг 5,619.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, ЕБС, цэцэрлэг, ЭМТ-ийн тогтмол зардлуудыг 94,273.6 мянган төгрөгөөр, ОНХО-ын зардлыг 43,236.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 551,253.7 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 316,938.1 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 451,018.6 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 110,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 369,614.7 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 34,125.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **1,832,950.1** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 551,253.7 мянган төгрөгийг аймгийн төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 316,938.1 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 7,336.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 925,623.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 85,254.8 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **1,886,406.9** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,382,416.3** мянган төгрөг буюу **75.4** хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 58,557.4 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 50,291.3 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 25,144.0 мянган төгрөгөөр эргэж төлөгдөх зээлийн зардал 182,400.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 17 төсөл, арга хэмжээнд 601,972.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 484,057.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 89,287.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь малын тоо толгойн албан татварын

орлогоор хийх 3 төсөл, арга хэмжээнд иргэдийн санал аваагүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 2,954.1 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 352,127.1 мянган төгрөг /ОНХО, ОНХС-аас эрх шилсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт 326,432.5 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс ХАА-н тооллогын санхүүжилт 4,594.6 мянган төгрөг, нийтийн биеийн тамирын арга хэмжээний 800.0 мянган төгрөг, БОАЖГ-аас дэмжлэг үзүүлэх ажлын санхүүжилт 20,000.0 мянган төгрөг/, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 9,801.3 мянган төгрөг зэрэг нийт 364,882.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 38,449.9 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 326,432.5 мянган төгрөг зэрэг нийт 364,882.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруунбүрэн сумын ТТЗ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 3,813,219.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **38,132.9** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг болсон тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,043,312.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон **20,866.2** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Баруунбүрэн сумын ТТЗ нь батлагдсан төсвийг 24.6 хувиар хэмнэсэн болон бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашиглаж, бичиг хэргийн зардлыг хэмнэж ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтуудыг зөрчсөн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд ИТХ нь 1,000.0 мянган төгрөгийн шагналын зардал, ЗДТГ нь 2,000.0 мянган төгрөгийн хүнсний материалын зардал зэрэг нийт **3,000.0** мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5. дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-дэх” Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	155	106	49	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	132	19	
3	Засаг даргын Тамгын газар	151	145	6	
4	Орхон бүсийн сум дундын ойн анги	151	103	48	
	Нийт дүн	608	486	122	

Эх сурвалж: old.shilendans.gov.mn

ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 608 мэдээллээс 486 мэдээллийг хугацаанд нь, 122 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэлт: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Уранцэцэг, Орхон бүсийн Ойн ангийн нягтлан бодогч Б.Батзул нарт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. ОНХС-ийн дансанд төвлөрсөн Малын хөлийн татварын орлогоос мялзан, шүлхий өвчинтэй тэмцэх ажлын шатахууны / *Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэх ёстой* / зардалд 3,637.4 мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 3 дахь “*Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно.*” 60.3.6 “*Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ОНХС-ийн зардлыг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 213,030.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 23,737.3 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 118,633.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	23,737.3	3	22,217.3	75.0
Зөвлөмж	3	118,633.3	2	27,194.8	66.7
Нийт дүн	7	142,370.6	5	139,762.1	71.4

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргасан зөрчил дараах шийдлүүдийг хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэх.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх гэсэн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүй тайланд онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг

үндэслэн сумын ЗДТГ-ын дарга Л.Балжиннямд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэх.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

4.8.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудит болон бусад аудитиудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

4.8.3 Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн авлагад 77,868.9 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 2011-2018 онд олгосон 8 иргэний 20,900.1 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг холбогдох шатны шүүхэд хандаж шийдвэрлүүлэх шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,233.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 450.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 15,783.3 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Орхон бүсийн ойн ангийн техникч Д.Дарханцэцэгт олгосон **450.0** мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Суутгаагүй цалингийн урьдчилгааг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.1 Албан шаардлага

5.2.1 Сумын ЗДТГ нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас хоол, хүнсний материалын зардалд 8,050.2 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 1,895.0 мянган төгрөг зэрэг нийт **9,945.2** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж: *“Байгууллага гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх зардлыг энэ ангилалд бүртгэнэ.”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төлөвлөлийг зардлын эдийн засгийн үнэн зөв төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс нийт **2,694.9** мянган төгрөгийн /ЗДТГ нь 1,694.9 мянган төгрөг, Ойн анги 1,000.0 мянган төгрөг/ бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2.3 Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээний үйл ажиллагаанд зориулан нийт **3,000.0** мянган төгрөгийн дараах зардлуудыг санхүүжүүлж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- ИТХ нь нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас уралдаан тэмцээний шагналд 1,000.0 мянган төгрөг,
- ЗДТГ нь төлбөр хураамжийн зардлаас хоол, хүнсний материалд 2,000.0 мянган төгрөг зэрэг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалт болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.2.4 Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс Орхон бүсийн Ойн анги нь **143.2** мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэж, санхүүгийн тайланд тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан

бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах, төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
ИТХ	1	1,000.0			1	1,000.0							
ЗДТГ	3	13,640.1			3	13,640.1			2	2			
Ойн анги	3	1,593.2	1	450.0	2	1,143.2			1	1			
Дүн	7	16,233.3	1	450.0	6	15,783.3			3	3			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1						1	
ИТХ	1						1	
ЗДТГ								
Ойн анги	1						1	
Дүн	3						3	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ	1	3,637.4					1	3,637.4
Дүн	1	3,637.4					1	3,637.4
Нийт дүн	4	3,637.4					4	3,637.4